



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Олон Улсын Улаанбаатарын их сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Гадаад хэлний орчуулга (Англи хэл)**

Индекс: **D023101**

Шинжээчийн баг:

Ахлагч: Т.Төрбат /Хэл шинжлэлийн ухааны доктор,  
профессор/

Гишүүд: Р.Наранцэцэг /ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн  
Англи хэлний тэнхимийн профессор/

Ч.Шинэбаяр /Дээд боловсрол судлаач/

Он сар өдөр: 2021-03-04

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл  
МХЕГ – Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар  
МОХ – Монголын оюутны холбоо  
БНСУ – Бүгд найрамдах Солонгос Улс  
БСШУЯ – Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яам  
МИАТ ТӨХК – “Монголын Иргэний Агаарын Тээвэр” төрийн өмчит хувьцаат компани  
ОУУБИС – Олон улсын Улаанбаатарын их сургууль  
ДС – Дээд сургууль  
ИДС – их, дээд сургууль  
ОЗ- -Оюутны зөвлөл  
ӨҮТ – Гадаад хэлний орчуулга /Англи хэл/ хөтөлбөрийн магадлаг итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан  
АХТ – Англи хэлний тэнхим  
ХДЧБ – Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын төв  
ХЕХ – Хөтөлбөрийн ерөнхий хороо  
CDIO – Conceiving – Designing – Implementing - Operating  
CEFR – Европын Холбооны Гадаад Хэлний Нийтлэг Стандарт  
PLO – хөтөлбөрийн суралцахуйн үр дүн  
PDCA – Plan – Do – Chek – Act  
PPP – Presentation, Practice and Production  
ЕБС – ерөнхий боловсролын сургууль

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Олон Улсын Улаабаатарын их сургууль /ОУУБИС/ International University of Ulaanbaatar /IUU/	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Гадаад хэлний орчуулга /Англи хэл/ Foreign language translation /English/	
<b>Индекс</b>	D023101	
<b>Шинжээчид</b>	Ахлагч: Т.Төрбат Гишүүд: Р.Наранцэцэг Ц.Шинэбаяр	
<b>БМИУЗ-ийн Мэргэжилтэн</b>	Н.Түмэнжаргал	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр/цаг</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	<b>2021-03-03</b> 10:30-11:00	Нээлт
	11:00-12:00	Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах.
	12:00-13:00	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
	13:00-14:00	Завсарлага
	14:00-15:00	Оюутнуудтай хийх уулзалт /цахим/
	15:00-16:00	Багш нартай хийх уулзалт
	<b>2021-03-04</b> 10:00-11:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах.
	11:00-12:00	Ажил олгогчидтой хийх уулзалт /цахим/
	12:00-13:00	Төгсөгчидтэй хийх уулзалт /цахим/
	13:00-14:00	Завсарлага
	14:00-15:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах, шинжээчийн багийн уулзалт
	15:30-16:00	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх

<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан болон холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны Захирлын 2021 оны 02 сарын 10-ний өдрийн А/27 тушаал.
----------------------------------	---

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Олон Улсын Улаанбаатарын их сургууль нь 1995 онд “Улаанбаатар коллеж” нэртэй байгуулагдаж, өргөжсөөр 2015 оноос “Олон Улсын Улаанбаатарын их сургууль” болон үйл ажиллагаагаа явуулж байгаа. Өнгөрсөн хугацаанд 8,000 гаруй боловсон хүчнийг хүмүүнлэг, хөдөө аж ахуй, инженер, сувилахуй, хууль, эдийн засаг гэсэн 6 салбарт 30 гаруй мэргэжлээр бэлтгэсэн байна.

Тус сургууль **Эрхэм зорилгоо**: Олон улсын түвшний боловсрол эзэмшүүлж, Монголын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үнэнч шударга, хүний эрхийг дээдэлдэг, итгэл найдвар хайрыг эрхэмлэдэг, хөрвөх чадвартай хүнийг бэлтгэхэд оршино.

**Үзэл баримтлалаа**:

Итгэл (Faith) - Үнэнч, зөв хүмүүжилтэй, бусдын итгэлийг даадаг хүн

Найдвар (Hope) - Мэргэжлээрээ өсөх хүсэл тэмүүлэлтэй, бүтээлч, улс орон, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг хүн,

Хайр (Love) - Өөрийн улс үндэстэн, хүн төрөлхтнийг хайрладаг хүн,

**Алсын хараагаа**: “Олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай Монголын хувийн шилдэг их сургууль болохын тулд 2025 он хүртэл дэлхийн түвшний нэг тэнхим, Азийн түвшний хоёр тэнхим Монголдоо тэргүүлэх түвшний гурван тэнхимийг бий болгоно” хэмээн тус тус тодорхойлсон байна.

Эдүгээ ОУУБИС нь Хууль зүйн сургууль, Сувилахуй сургууль, Хүмүүнлэгийн ухааны сургууль, Хөдөө аж ахуй инженерийн сургууль, Эдийн засгийн сургууль, Суурь боловсролын сургууль гэсэн 6 бүрэлдэхүүн сургуулийн 14 тэнхимд 31 мэргэжлээр баклаврын, төгсөлтийн дараах сургуульдаа 10 чиглэлээр магистрын, 3 чиглэлээр докторын түвшний сургалтыг явуулдаг сургалт, судалгааны их сургууль болж ажиллаж байна. Одоо 170 гаруй багш, ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

ОУУБИС-ийн нийт багш нарын 40-өөд хувь нь, монгол багш нарын 50-иад хувь нь эрдмийн зэрэгтэй, эрдэмтэн багш нар болсон. Сургуулийн захиргаа нь амжилттай суралцаж буй оюутнуудынхаа сургалтын төлбөрийг 30-100 хувь хөнгөлөхөөс гадна сурах чин хүсэлтэй боловч амьдралын бололцоо тааруу оюутнуудаа дэмжин сургалтын тэтгэлгийг 30-100 хувь, спорт, урлагийн төрлөөр амжилт гарган сургуулийнхаа нэрийг гарган хот, улс, олон улсын чанартай тэмцээн, уралдаанд оролцсон оюутнуудаа 50-100 хувь хүртэлх сургалтын тэтгэлэгт тогтмол хамруулдаг байна. Түүнчлэн удирдах зөвлөлийн дарга болон ерөнхий захирлын нэрэмжит, Дун Инь, Чон Хи Чоль, Пёнбуг зэрэг байгууллага хувь хүний нэрэмжит, нийгмийн үйлчилгээ, цагийн ажлын тэтгэлэгт жилд дунджаар нийт оюутны 17%-д тэнцэхүйц оюутнууд хамрагдаж байгаа нь ОУУБИС-ийн удирдлагуудын талаас цаг үеэ олсон ажил болж байна.

ОУУБИС 2002 оны 05-р сард *Англи хэлний орчуулагч* мэргэжлээр бакалаврын анги нээх зөвшөөрөл авсан. 2006 онд Англи хэлний орчуулагч мэргэжлээр анхны төгсөлт хийсэн.

Англи хэлний сургалт, хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан Англи хэлний тэнхим 2002 онд байгуулагдсан. Тус тэнхим мэргэжлийн англи хэлний сургалт хариуцаж англи хэлний багш болон орчуулагч бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн боловсруулдаг. Мөн тэнхимээс ОУУБИС-ийн хамтын ажиллагаа, гадаад харилцааны хүрээнд БНСУ, БНХАУ, АНУ, ОХУ, Австрали, Филиппин, Кыргызстан зэрэг улсын нийт 97 их сургуультай хамтын ажиллагааны гэрээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож ажилладаг. Энэ хүрээнд оюутан солилцоогоор явуулах, зочин багшаар урьж ажиллуулах, эрдэм шинжилгээ судалгаа хийх зэргээр дараах сургуулиудтай ойр хамтран ажиллаж байна. Үүнд: Сөүлийн эмэгтэйчүүдийн их сургууль, PAS байгууллага, Санмён, Ханян, Хансэ, Чонбуг, Ча анагаахын их сургууль, ОХУ-ын Буриадын Улсын Их Сургууль, ӨМӨЗО-ны Хайлаарын их Сургууль тус тус байна.

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орох зорилгоор тус тэнхимээс 2021 онд ӨҮТ гаргаж ирүүлсэн англи хэлний орчуулагч мэргэжлээр 2006 оноос хойш 270 орчуулагч төгсгөн гаргажээ.

Жил бүр суралцагчдаас шилдгийг нь сонгон шилдэг оюутны тэтгэлэг олгодгоос гадна урлаг, спорт, нийгмийн үйлчлэл, байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит болон элсэгчдийн жагсаалтад тэргүүлэгчдэд олгох тэтгэлэгт оюутнаасаа хамруулдаг. Тэнхим, сургуулийн зүгээс болон эрдэм шинжилгээ, багшийн хөгжлийн төв хамтран багш бүрийн ажлын тайланд дүн шинжилгээ хийж, цаашдын зорилтоо Стратеги төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх зорилтыг тавьж ажиллаж байгаа.

Тэнхим нь англи хэлний сонсох, ярих, бичих, орчуулах чадварыг эзэмшсэн, Их Британи болон Америкийн түүх, соёл, ёс заншил, нийгэм-эдийн засгийн талаарх мэдлэгтэй, англи хэлний хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан, сургалтыг орчин үеийн шинэ технологиор зохион байгуулдаг, эх хэл соёлоо англи хэл бусад үндэстний хэл соёлтой харьцуулан судалдаг, гадаад хэл заах арга зүй, боловсрол судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийдэг, өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, бусадтай хамтарч багаар ажилладаг, нийгмийн өөрчлөлтийг мэдэрч, дасан зохицож амьдрах чадвартай, эерэг хандлагатай, харилцааны соёлтой, мэргэжлийн ёс зүйтэй багш болон мэргэшсэн орчуулагч бэлтгэх зорилготой ажилладаг.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- Англи хэлний орчуулагч мэргэжлийн монгол дахь зах зээлийн эрэлт нь ЕБС-иудад англи хэл нийтлэг судалдаг, англи хэлний орчуулагчийн ангийн төгсөгчид төрийн болон төрийн бус байгууллагуудад ажиллаж хөрвөх бололцоо их, мөн хөтөлбөрийг сайжруулах зорилгоор дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулахдаа “Гадаад хэлний орчуулга, /англи хэл/-ээр бэлтгэдэг МУИС, МУ-ын Эрдмийн их сургууль, Италийн UNINT их сургуулийн “Гадаад хэлний орчуулга, хэлмэрчлэхүй”, Туркийн Eastern Mediterrean” их сургуулийн “Орчуулга, хэлмэрчлэхүй”-н сургалтын төлөвлөгөөтэй харьцуулсан судалгаа
- 2016 онд мэргэжлийн суурь ба мэргэших хичээлийн багц цагийг шинэчлэн баталсан хөтөлбөрөө 2017-2018 онд хөтөлбөрөөр дахин хянаж хүрэх үр дүн, сурах, сургах арга, үнэлж дүгнэх үйл ажиллагааг илүү тодорхой болгон онол, хэл соёл, орчуулга 3 үндсэн чиглэлээр оюутны эзэмших мэдлэг чадварыг тодотгон тодорхойлсон баримт
- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургалтын хөтөлбөр

##### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-д дадлагын ажлыг бүгд 14 кредит ба 3 үе шаттайгаар хийж аман буюу хэлмэрчлэхүй болон бичгийн орчуулгыг тус тусад нь хийдэг нь англи хэлний орчуулагч мэргэжилтэн бэлтгэдэг хөтөлбөрийн нэг онцлог тал болж байна.

##### Анхаарах асуудал:

- Англи хэлний орчуулагч мэргэжлээр төгссөн төгсөгч өөр салбарт хөрвөж ажиллах боломж их байгаа нь тухайн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай болохыг нотолж байгааг харгалзан оюутанд санал болгох төлөвлөгөөнд ажил олгогчдоос санал авч, орчуулгын сонгон суралцах хичээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх.

##### Зөвлөмж:

- Англи хэлний орчуулагч мэргэжлээр төгссөн төгсөгч өөр салбарт хөрвөж ажиллаж байгааг харгалзан төгсөгчдийн уулзалт зохион байгуулж санал авах, төгсөгчдийг

мөшгөх судалгааг ажлын байр, ажилладаг салбараар төрөлжүүлэх арга замаар орчуулгын сонгон суралцах хичээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн зорилгоо сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан тодорхойлсон байдал
- Хөтөлбөрийн зорилго зорилтыг сүүлийн 3 жилд хоёр дахь удаагаа шинэчлэснээр хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг чадвар болон хүрэх үр дүн, сурах, сургах арга, үнэлж дүгнэх үйл ажиллагааг илүү тодорхой болгон хөтөлбөрийн зорилго зорилтууд хоорондын уялдаа, холбоог гаргахад анхаарч ажилласан байдал
- Сургалтын төлөвлөгөөнд үе шаттай үнэлгээ хийж 2016, 2018 онд шинэчлэн баталсан байдал
- Сургалтын хөтөлбөр
- Өөрийн үнэлгээний тайлан

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчийн загварыг хэл, соёл, хэл шинжлэл, мэргэжил 4 хүрээнд хөтөлбөрөөр хүрэх үр дүнгийн үндсэн 3 чиглэлд авч үзэж байгуулсан.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн боломжит ажлын байрыг тодорхойлсон.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн гадаад хэлний мэдлэгийн түвшинг хэмжиж үнэлсэн үйл ажиллагаа, энэ талаар ажил олгогчдын өгсөн үнэлгээнд хийсэн дүгнэлтийг хөтөлбөрийн хичээлийн стандартыг боловсруулалтад байнга тусгах.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн гадаад хэлний мэдлэгийн түвшинг хэмжих, үнэлэх үйл ажиллагаанд болон сургуулиа төгсөөд ажиллаж байгаа төгсөгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарсан судалгаа хийх.

## **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**



- Батлагдсан хөтөлбөр, нэгдсэн төлөвлөгөөг тайланд оруулсан ба батлагдсан хичээлүүдийн хөтөлбөр
- Сургалтын төлөвлөгөөний одоогийн бүтцийг БСШУЯ-ны Сайдын А174 тушаалтай нийцүүлсэн байдал
- Хөтөлбөрийн төлөвлөлтөөр өөрийн үнэлгээний тайлан гаргахдаа SWOT анализ хийсэн шинжилгээ

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн онцлогоороо Монгол дахь бусад ИДС-иас ялгарах талаар болон ОУ-ын магадлан итгэмжлэлд бэлтгэхэд анхаарсан.

#### Зөвлөмж:

- Онлайн сургалт явуулсан хугацааны туршлагадаа тулгуурлан оюутны суралцсан явцын үнэлгээнд дүгнэлт хийж багш сургах, оюутан бие даан сурах арга барилын талаар зөвлөмж боловсруулах.

### 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- Удирдлага, мэдээллийн систем ULMS/-ээр дамжуулан суралцагч суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөдөг байдал
- 2011 оноос 2018 онд англи хэлний орчуулагчийн хөтөлбөрт 6 удаа сайжруулалт, өөрчлөлт хийсэн болон нэгж хичээл болон хөтөлбөрийн үнэлгээг хийсэн байдал
- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын залгамж, холбоосыг харуулсан схем
- Суралцагч <http://info.ubu.mn> сайтаар дамжуулан оюутан өөрийн суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөдөг, багш, хичээл, хичээлийн хуваариа сонгодог байдал
- Өөрийн үнэлгээний тайлан

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага

- Сургалтын төлөвлөгөө нь лекц дадлагын хичээлийн зохистой харьцааг баримталсан,

- хичээлийн агуулга нь харилцан уялдаатай,
- Суралцагч цагийн ачааллаа 12-18 кредит хүртэл өөрөө зохицуулах, хичээл ба багшаа сонгох боломжийг тусгасан.

**Анхаарах асуудал:**

- Багш нарт зориулсан сургалтын аргазүйг хэрэгжүүлэх зөвлөмжийн ном, товхимол нэмэгдүүлэх.

**Зөвлөмж:**

- Багш нарт зориулсан сургалт-аргазүйн семинар зохион байгуулахдаа орчуулгын онол аргазүйн бүтээл туурвисан орчуулагч судлаач нартай болон орчуулагчтай уулзалт зохион байгуулах боломжоос ашиглах.

**2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээлийн стандартыг сургалтын төлөвлөгөө, сурах/сургах аргатай уяж хичээл заахад 20 гаруй хэлбэрийг ашигладаг байдал
- Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа анализ хийдэг, багшийн ур чадварыг оюутнаар үнэлүүлж сэтгэл ханамжийн судалгаанд харгалздаг баримт
- Өөрийн үнэлгээний тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Цар тахлыг харгалзан цахим хичээлийг “ЭДМОДО” платформоор явуулсан явцдаа дүгнэлт хийж “G suite for education” сургалтын эрх авч ашиглаж байна.

**Анхаарах асуудал:**

- “G suite for education” сургалт явуулсан явцаа дүгнэж үзэх

**Зөвлөмж:**

- Орчуулгын дадлагын хичээл дээр оюутан бие даан ажиллах, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, автомат орчуулгын технологигоос ашиглаж сурахад анхаарах.

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Оюутны мэдлэг чадварыг явцын улирлын үнэлгээ хийх журам, сайдын 2003 оны 158-р тушаал дагуу явуулдаг. Багшийн оруулсан үнэлгээ болон оюутны үзүүлсэн амжилтыг зэрэгцүүлэн шинжилгээ хийж багшийг үнэлсэн дүгнэлт гаргадаг.
- Хичээлийг нийт 12 төрлийн аргаар үнэлж ирсэн.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд амжилт дунджаар 90,51%, чанар 69,38% байгаа нь харьцангуй сайн үзүүлэлт юм.
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт хийдэг.

#### Анхаарах асуудал:

- Оюутан сонгохгүй үлдээдэг хичээл байдаг эсэх талаар тодорхойгүй.

#### Зөвлөмж:

- Оюутны дүнгийн талаар сургалтын албаны гаргадаг статистик чанарын болон тоон үзүүлэлтэд хийсэн анализыг дараагийн хичээлийн жилийн ажилд тусгаж байх аргачлалд анхаарах.

### 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нарын сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа,
- Сүүлийн 5 жилийн хөрөнгө худалдан авалтын мэдээ

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуулийн сургалтын орчныг үе шаттай, тогтвортой сайжруулж ирсэн байна.

- Мэдээллийн технологийн техник хэрэгслээр бүрэн хангагдсан. Анги танхимын хүрэлцээ, хангамж сайн.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурах орчныг бүрдүүлэх тал дээр анхаарч ажилладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, оюутнууд болон төгсөгчидтэй хийсэн уулзалтаас үзэхэд оюутнууд номын санд сууж ажиллах нөхцөлд төдийлөн сэтгэл хангалуун бус байна.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын үйл ажиллагааг онлайн орчинд явуулах нөхцөлөөр хангах зорилгоор 2020 онд байгуулсан онлайн хичээлийн бичлэг хийх мультимедиа студийг сургуулийн хэмжээнд тэгш, хүртээмжтэй ашиглах .

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- Цахим болон электорон хувилбартай ном сурах бичгийн судалгаа
- Сургалтын программ хангамж, Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Сургалт удирдах систем – Edmodo багшийн болон оюутны гарын авлага

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Анги танхимууд техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон нь цахим орчинд ажиллах, сургалтад аудио, видео эх үүсвэрүүдийг ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. Энд оюутнууд хичээлийн бус цагаар ажиллах боломжтой.
- 2020 онд байгуулагдсан Цахим мэдээллийн технологи, онлайн сургалтын төвөөс багш нарт зориулсан цахим орчинд сургалт явуулах, сургалтын е-контент бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, мэргэжлийн дэмжлэг үзүүлдэг.
- Сургуулийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилээс Google компаний G-suit for Education багц үйлчилгээг авч ашиглаж эхэлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Хэлний сургалтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх явуулах лингафоны кабинет, виртуал лаборатори дутмаг тул сургуулийн удирдлагад асуудлаа дэвшүүлэн шийдвэрлүүлэх.

#### **Зөвлөмж:**

- Багш нарын боловсруулж байгаа е-контентийн тоог нэмэгдүүлэх, интерактив цахим хичээлийн программ хангамжийг шинэчлэх.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш, оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Хөтөлбөрийн мэргэжлийн ном, сурах бичиг, хэвлэл, цахим номын бүтцийн судалгаа
- Хөтөлбөрийн сүүлийн 5 жилийн фонд бүрдүүлэлт, Сургалтад хэрэглэх номын захиалга (2020-2021)

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нарын номын захиалгад үндэслэн жил бүр номын фондын баяжуулалт, шинэчлэлт хийдэг.
- Номын фондын хүрэлцээний талаар оюутны сэтгэл ханамжийн судалгаа, номын фондын судалгааг тогтмол хийдэг.

##### **Анхаарах асуудал:**

- Номын фондын баяжуулалтыг тогтмол хийж байгаа ч тус хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудын 50 гаран хувь нь номын фондын хүрэлцээнд сэтгэл ханамж дунд ба түүнээс доош гэсэн үнэлгээ өгсөн.
- Номын фондын бүтцэд эрдэм шинжилгээний сэтгүүл, цахим номын эзлэх хувь бага.

##### **Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээний сэтгүүл, мэргэжлийн сэтгүүл болон цахим номын нэр төрөл, тоог нэмэгдүүлэх

##### **Шаардлага:**

- Номын фондын хүрэлцээг болон уншлагын танхимын орчинг сайжруулах
- Номын фондын бүтцэд эрдэм шинжилгээний сэтгүүл, мэргэжлийн сэтгүүл болон цахим номын нэр төрөл, тоог нэмэгдүүлэх

#### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх,

суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн хөтөлбөрийн хороо 2014 онд байгуулагдаж 2018 онд хорооны ажиллах журмыг шинэчлэн баталсан нотолгоо
- Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааг төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, сайжруулалтын үе шат бүрээр авч үзэж хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ, санхүүжилт, хөтөлбөрийн нээлттэй ил тод байдал хангах талаас нь нарийвчлаж удирдлага, зохион байгуулалтаа хийж ирсэн баримт
- Хичээл сонголт, сургуулийн удирдлагын системийн талаар сүүлийн 5 жилд оюутнуудаас ирсэн санал нийт саналын 31,4% эзлэсэн дагуу тэнхим, алба, нэгж, сургуулийн захиргаа шуурхай арга хэмжээ авч суралцах орчинг сайжруулах, сургалт оновчлох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд анхаарсан арга хэмжээнүүд авч зохих хөрөнгө оруулалт хийсэн баримт нотолгоо
- Өөрийн үнэлгээний тайлан

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын удирдлагын системд 4 дэд цахим систем ажилладаг бөгөөд ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө болон тэнхмийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн хөтөлбөрийн урт, богино хугацааны төлөвлөлт, хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тэнхмийн ажлын гүйцэтгэл, ахиц, дэвшилд хичээлийн жил бүр дүгнэлт хийдэг.
- Хөтөлбөрийн нээлттэй байдлыг хангаж сүлжээний програм хангамж ашигладаг.

##### **Анхаарах асуудал:**

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаанд орчуулагч мэргэжлээр тодруулсан судалгааг хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд авч үздэг болох.

##### **Зөвлөмж:**

- Залуу орчуулагчдын дугуйлан, эвсэл, нэгдлийн аль боломжтойгоос санаачлан байгуулж сургуулийн шилдэг номинацтай болох боломжийг судлах.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхижүүлэлтээр 5, олон нийтэд сурталчлахад 7 төрлийн үйл ажиллагааг явуулж ирсэн баримт. Үүнд: мэргэжил сурталчлах өдөрлөг, англиар илтгэл тавих уралдаан, спортын томоохон үйл ажиллагаа, ТВ, радио, цахим орчны зар сурталчилгааг өргөн ашигладаг.
- Хөдөлмөрийн зах зээлийг тандах судалгааг 4 төрлөөр:- ажил олгогчийн судалгаа, төгсөгчдийг мөшгөх судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын судалгаа, ажлын байрны эрэлт буюу сонин хэвлэл цахим группийн судалгаагаар тус тус хийсэн баримт
- Мэргэжлийн, төрийн, төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоон гурван талт гэрээ хийж оюутны дадлага, хөдөлмөрлөх хүчний хэрэгцээний судалгаа хийх, хамтран тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлдэг байдал
- Гадаад хэлний орчуулга /англи хэл/ хөтөлбөрийн оюутан солилцоогоор соёлын хөтөлбөрөөр 2, Сүгмөн их сургуульд суралцах хөтөлбөрт нэг нийт 3 оюутан хамрагдсан баримт

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хонконг, АНУ, Австрали, Филиппинээс зочин багш урьж ажиллуулсан. Австри, БНХАУ-д 2 багш явж ажилласан.

#### **Анхаарах асуудал:**

- ОУУБИС-иас гадаад харилцаагаар 90 гаруй их дээд сургуультай гэрээтэй ажиллаж байгаа өргөн боломжийг англи хэлний орчуулагч мэргэжлээр багш болон оюутан солилцоонд өргөн ашиглах.
- 2+2 хөтөлбөрөөр оюутан сургах цаашдын боломжоо бүрэн ашиглах, ийм хөтөлбөрт хамрагдах оюутан зорилттой бэлтгэхэд анхаарах.

#### **Зөвлөмж:**

- ОУУБИС-иас гадаад харилцаагаар 95 их дээд сургуультай гэрээтэй ажиллаж байгаа өргөн боломжийг багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг олон хэлбэрийн хамтын ажиллагаагаар англи хэлний орчуулагч бэлтгэх сургалтын чиглэлээр идэвхжүүлэх, англи хэлний орчуулгын дадлагаар оюутан солилцоог идэвхтэй ашиглах талаар судлах.

#### **Шаардлага:**

- ОУУБИС-иас гадаад харилцаагаар 90 гаруй их дээд сургуультай гэрээтэй ажиллаж байгаа өргөн боломжийг англи хэлний орчуулагч бэлтгэх сургалт, англи хэлний орчуулгын дадлагаар оюутан солилцоох солилцоонд идэвхтэй ашиглаж ийм гэрээгээр дадлага хийх оюутны тоог нэмэгдүүлэх.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн санхүүжилт сургуулийн нэгдсэн төсвийн хүрээнд зохицуулагддаг баримт
- 2019-2020 онд нэг оюутанд дунджаар 2599,1 мян.₮ зардал ногдож байна. Хичээлийн жилийн зардлыг сая төгрөгөөр задалснаас үзвэл 94,3 нь сургалтын шууд зардал, шууд бус зардалд 14,8, хөрөнгө оруулалтад шилжүүлдэг зардал 5,3, нийт төсвийн дүнгээр 114,4 сая₮ байна. Сургуулийн ашиг 7,98сая₮ байхаар төлөвлөгдсөн баримт нотолгоо
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэгээр 2019-2020 онд 23 оюутанд 13,14сая₮ олгогдож үүнээс гаднын байгууллагын тэтгэлэгт 17 оюутан хамрагдсан баримт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжилд 2019-2020 онд 2387925,58₮ зарцуулах, үүний дотор шагнал, тэтгэлэгт 1500000,0₮ мэргэжил дээшлүүлэх семинар сургалтанд 272735,0₮ төлөвлөсөн гэх боловч орчуулагч мэргэжлийн дагуу хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлт, дэмжлэгэд зориулах, эсвэл зориулж болох зардал тодорхойгүй.

### **Зөвлөмж:**

- Оюутан солилцооны хөтөлбөрүүдийг идэвхжүүлэх, суралцах хугацаандаа оюутан бүр ямар нэг хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн идэвхижүүлэлтээр 5, олон нийтэд сурталчлахад 7 төрлийн үйл ажиллагааг явуулж ирсэн баримт /Тайлангийн 78-р хуудас./ Үүнд мэргэжил сурталчлах өдөрлөг, англиар илтгэл тавих уралдаан, спортын томоохон үйл ажиллагаа, ТВ, радио, цахим орчны зар сурталчилгааг өргөн ашигладаг.
- Хөдөлмөрийн зах зээлийг тандах судалгааг 4 төрлөөр:- ажил олгогчийн судалгаа, төгсөгчдийг мөшгөх судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын судалгаа, ажлын байрны эрэлт буюу сонин хэвлэл цахим группийн судалгаагаар тус тус хийдэг баримт нотолгоо

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2020 оноос оюутан болон эрдэмтэн багш нарын podcast цуврал санаачилсан.

### **Анхаарах асуудал:**



- Хөтөлбөр, мэргэжлээ олон нийтэд сурталчилах ажлын цар хүрээ ЕБС-д зохион байгуулдаг спортын арга хэмжээгээр хязгаарлагдахгүй байлгахад анхаарах.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад 3 жилд нэг удаа явуулдаг судалгаа үр дүн багатай байх магадлалыг анхаарч судалгааны давтамжийн хугацааг богиносгох.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Элсэгчдэд зориулсан сэтгүүл, брошюрыг жилд 2 удаа тогтмол хэвлэн нийтэд нээлттэй тараадаг баримт
- Боловсрол ТВ-тэй хамтран гэрээтэй ажиллаж солонгос хэлний онлайн хичээлийг нийтийн хүртээл болгосон баримт
- Сургуулийн үйл ажиллагааны мэдээллийг Өнөөдөр, Өдрийн мэдээ зэрэг сониноор дамжуулан тараадаг баримт
- Өөрийн үнэлгээний тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн вэб хуудсаар дамжуулан сургуулийн болон мэргэжил тус бүрээр хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар иж бүрэн мэдээлэл түгээж эргэх холбоог хангасан.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхмийн гадаад харилцааг сайжруулах, БНСУ-ын ИДС-тай оюутан болон кредит солилцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

**Зөвлөмж:**

- Гадаадад багш нараа түр хугацаагаар сургах, мэргэшүүлэх сургалтад хамруулахад гадаадын гэрээт сургуулиудын боломжийг ашиглахад анхаарах.

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

## 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

### Илрэл нотолгоо:

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- ОУУБИС-ийн Бакалаврын сургалтад оюутан элсүүлэх журам, Гадаад оюутан элсүүлэх жура,
- Оюутны гарын авлага
- Элсэлтийн дүн мэдээ
- Оролцогч талуудтай хийсэн цахим уулзалт

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийг Сургалтын алба, Элсэлтийн комисс, тухайн тэнхим хамтран зохион байгуулдаг бөгөөд сүүлийн 6 жилд элсэлттэй холбоотой зөрчил гараагүй байна.
- Тус хөтөлбөрт элсэгчдийн сүүлийн 6 жилийн ЭЕШ-ийн дундаж оноо 523,5 байгаа нь босго онооноос 110-120 оноогоор дээгүүр байна.
- Сургалтын албанаас шинэ оюутнуудад зориулсан чиглүүлэх, танилцуулах өдөрлөг зохион байгуулдаг бөгөөд мэргэжлийн тэнхимээс шинэ элсэгчдэд кредит систем, хичээл сонголт, хичээлийн хуваарь, тэнхим үйл ажиллагааны талаар мэдээлэл өгдөг.
- Суралцах үйл ажиллагаагаа төлөвлөхөд туслах үүрэг бүхий зөвлөх багшийг томилон ажиллуулдаг байна.
- Гадаад оюутны тоо нэмэгдсэн. Монгол туургатныг дэмжих үүднээс тэднийг дотоодын оюутантай ижил төлбөртэй сургадаг.

### Анхаарах асуудал:

- Элсэлтийн тоо нилээд хэлбэлзэлтэй, тухайлбал сүүлийн 6 жилд тус хөтөлбөрөөр 17, 9, 30, 11, 6, 22 оюутан элссэн байна.

### Зөвлөмж:

- Элсэлтийн тоог тогтвортой байлгахад анхаарах.

## 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### Илрэл нотолгоо:

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутны болон төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн онлайн уулзалт
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийн танилцуулга

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимээс томилогдсон зөвлөх багш нь оюутанд суралцах, судлах арга зүйн зөвлөгөө өгдөг. Зөвлөх багш болон тэнхимийн нийт багш нарын зөвлөн туслах үйлчилгээг оюутнууд болон төгсөгчид маш өндрөөр үнэлсэн болно.
- Тус сургууль нь Хууль зүйн зөвлөгөө өгөх өрөө, Гэр бүлийн зөвлөгөө, боловсролын онол, арга зүйн төвтэй бөгөөд оюутнууд эндээс үнэ төлбөргүй зөвлөгөө авах боломжтой.
- Оюутнуудад зориулсан хувь хүний хөгжлийн сургалтыг 2013-2014 оны хичээлийн жилээс тогтмол зохион байгуулж байна.

### Анхаарах асуудал:

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвөөс санал болгож байгаа ажлын байр нь оюутны эрэлтэд төдийлөн нийцдэггүй, ажлын хөлс бага байдаг байна.

### Зөвлөмж:

- Оюутнуудыг суралцаж байгаа мэргэжлээр нь цагийн ажилд зуучлах, төгсөгчдийг ажлын байранд зуучлах талаар илүү санаачлагатай ажиллах.

### 5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### Илрэл нотолгоо:

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- ОУУБИС-ийн “Оюутны тэтгэлгийн журам” (2018)
- Оюутнуудад зориулсан дугуйлан хичээллэх улирлын хуваариуд, бүртгэлийн хуудас
- Оюутны болон төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн онлайн уулзалт

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-ийн хэмжээнд суралцагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн 20 гаран дугуйлан тогтмол ажиллаж байна. Тус хөтөлбөрийн багш нар оюутны англи хэл сурах сонирхлыг идэвхжүүлэх, дүрмийн болон яриа, орчуулгын чадварыг хөгжүүлэх дугуйлангуудыг хичээллүүлдэг.
- Суралцагчдын сургалтын чанарыг сайжруулах, нийгмийн халамж үйлчилгээг дэмжих, амьдралын нөхцөл байдалд туслах зорилгоор нийт 11 төрлийн тэтгэлэг олгодог байна.
- Оюутны сайн дурын ажлыг үнэлэн 2011 оноос Нийгмийн үйлчилгээний тэтгэлэг олгож эхэлсэн. 2019 оноос эхлэн тэнхим бүрт тодорхой тооны квот олгодог болсон байна.

**Анхаарах асуудал:**

- Тус хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд сургууль, тэнхимдээ зохион байгуулдаг уралдаан тэмцээнд идэвхтэй оролцдог боловч 2017 оноос хойш олон улсын болон улсын хэмжээний уралдаан тэмцээнд оролцоогүй байна.

**Зөвлөмж:**

- Англи хэлний мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудыг хувьд олон улсын уралдаан тэмцээнд оролцох боломж, давуу тал байгааг оюутнууддаа мэдрүүлэх, тэдэнд зөвлөн чиглүүлэх талаар санаачлагатай ажиллах.

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- “Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журам” (2018)
- Сургуулиас чөлөөлөгдөж байгаа шалтгааныг тодруулах судалгаа
- Шилжилт хөдөлгөөний тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Зөвлөх багш нь оюутны сурах идэвхи буурах, сургуулиас хөндийрөх тохиолдолд оюутантай болон түүний эцэг эхтэй уулзаж, асуудлыг ярилцан зөвлөгөө өгдөг байна.

**Анхаарах асуудал:**

- Тус хөтөлбөрийн хувьд сүүлийн 5 жилд жилийн чөлөө авсан оюутан 20, сургуулиас гарсан оюутан 36, улирсан оюутан 51 байгаа нь оюутны тоотой харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

**Зөвлөмж:**

- Сургуулиас чөлөөлөгдөж байгаа шалтгааныг тодруулах судалгаанд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хугацаа алдахгүй авах

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- “Гадаад хэлний орчуулга /англи хэл/” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- ОУУБИС-ийн “Төгсөлтийн шалгалтын журам”
- “Оюутныг төгсгөх журам” (2019)

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан, төгсөгчид, ажил олгогчдын төлөөлөл тус сургуулийн төгсөгчдийн хувь хүний хандлага, хариуцлагатай байдал, харилцааны ур чадварыг өндрөөр үнэлж байна.

#### Анхаарах асуудал:

- Сүүлийн 6 жилийн төгсөгчдийн дөнгөж 2.2% нь дипломын ажил хамгаалсан байна. Оюутнуудыг судалгааны арга барилд сургах, судалгааны ажилд сонирхолтой болгох, улмаар дипломын ажил бичих оюутны тоог нэмэгдүүлэхэд анхаарах

#### Зөвлөмж:

- Төгсөлтийн бичиг баримтад зөвхөн дүнгийн хавсралтаар хязгаарлахгүй тухайн төгсөгчийн эзэмшсэн мэдлэгийн агуулга, ур чадварыг багтаасан бүрэн дүүрэн мэдээллийг хавсаргаж өгөх (Diploma supplement)

### 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн нийт багш нарын 44% нь докторын зэрэгтэй. Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг хамт олоны нийт (6) багшийн 50% нь эрдмийн зэрэг цолтой, 50% нь судалгааны ажил бичиж байгаа баримт нотолгоо
- Англи хэлний тэнхимийн нийт багш нарын ихэнх нь сургуульдаа 10 - 16 жил тогтвор суурьшилтай ажилласан нь мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй болсныг харуулна. Хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн багшийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь оюутны дадлагын ажил билээ. Энэ талаархи материалтай танилцсан байдал. Үүнд:
  - Дадлагын удирдамж /Англи хэлээр/
    - Үнэлгээний задаргаа тодорхой бөгөөд мөн англи хэлээр
    - Гурвалсан (багш, оюутан, ажил олгогч) гэрээ англи хэлээр

- Оюутан тус бүрийн дадлагын дүн битүүмжлэн багшид ирдэг баримт нотолгоо
- Багшийн албан тушаалыг профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 5 зэрэглэл тогтоон тус бүрд нийцсэн шаардлага боловсруулан журам мөрддөг байдал
- Багшийн үндсэн цалин сүүлийн 3-5 жилд нэмэгдсэн эсэх тайланд дурьдагдаагүй боловч тэтгэмж тусламж олгох журмаар 5 жилийн хугацаанд 10 гаруй сая төгрөгний тэтгэмж, урамшуулал олгосон баримт нотолгоо

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Албан тушаалын зэрэглэлийн шаардлага хангасан тохиолдолд жилд 2 удаа багшийн материалыг хүлээн авч зэрэглэл ахиулдаг нь сайшаалтай.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн сургалтын цагийн ачаалал 13-19 кр байгаа нь бусад их дээд сургуультай харьцуулахад өндөр байна. Цаашид сургалтын цагийг бууруулан эрдэм шинжилгээ судалгааны цагийг өсгөх нь өнөөгийн их сургуулийн шаардлагад илүү нийцэн, багшийн хөгжилд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

#### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2014 онд багшийн хөгжлийн хөтөлбөрийг, 2015 онд тэнхимүүдийн судалгааны ажлын үндсэн чиглэлийг баталсан баримт
- Багшийн хөгжлийн төвтэй танилцсан байдал
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч Англи хэлний тэнхмийн багш нар мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн өөрийгөө хөгжүүлэх ойрын, дундын, хэтийн төлөвлөгөөтэй ажилладаг байдал.
- Тайлангийн хугацаанд 2 багш докторын (Ph.D) зэрэг хамгаалсан баримт
- Тэнхимийн бүх багш тайлангийн хугацаанд дотооддоо 1 сараас 1 жил хүртлэх сертификаттай сургалтад хамрагдан мэргэжлээ дээшлүүлсэн баримт
- Багш нартай хийсэн уулзалт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Англи хэлний мэргэжлийн тэнхмийн багш нарыг TOEFL, IELTS сургалтад хамруулан шалгалт өгөх талаар анхаарах нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нэг үзүүлэлт болох юм.

### **Зөвлөмж:**

- Гадаадад зохион байгуулж буй олон улсын хуралд илтгэл тавих, гадаад хамтын ажиллагааг ижил хөтөлбөр хэрэгжүүлдэг аль нэгэн орны улсын сургуультай холбоо тогтоон хөгжүүлэх.

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- ЭША эрчимжүүлэх тогтолцоо
- ЭША-ын цахим мэдээлэлийн систем,
- ЭШ-ний ISBN индекстэй сэтгүүлтэй бөгөөд англи хэлний багш нар өөрийн хувь нэмрийг зохих түвшинд оруулан сэтгүүлийн редакцийн зөвлөлд ажиллах, хамтарсан төсөлд гишүүнээр оролцох, орчуулга хийх зэрэг ажлууд хийж ирсэн баримт
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөгөө өгч тайлангийн хугацаанд нийт 97 бүтээл нийтлэгдсэнээс өгүүлэл—5, илтгэл-33, гарын авалга-13, ном сурах бичиг-14, хамтын бүтээл-1, зохиогчийн эрх -1 байна.
- Тус тэнхмийн багш нарын судалгаа шинжилгээний ажлыг дэмжин 5 жилийн хугацаанд 10 гаруй сая төгрөгийг зарцуулсан баримт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны дунд англи хэлээр Best presenter уралдаан зохион байгуулж уламжлал болгосон бөгөөд сэдэв нь чөлөөт байдаг нь судалгааг сонирхлын дагуу хийж ур чадвараа хөгжүүлэх үр өгөөжтэй боломж олгожээ .

### **Анхаарах асуудал:**

- Цаашид багш нар өөрийн эрдмийн бүтээлд зохиогчийн эрх авахад анхаарах

### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

### **Илрэл нотолгоо:**

- Үнэлгээг аттестачлал, өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ гэсэн 3 аргаар явуулж, аттестачлалыг 6 шалгуур, 30 үзүүлэлтээр шалган дүгнэдэг, ялангуяа сурган сэтгэл

судлалын шагалт авч онолын мэдлэгийг сэргээх нь багшийн үнэлгээний шаардлагад нийцэж байна гэсэн дүгнэлт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийг аттестачлах үнэлгээнд сурган, сэтгэл судлалын шалгалт авдаг нь мэдлэгийн (hard skill) болон мэдрэмжийн (soft skill) чадвар хөгжүүлэх орчин үеийн шаардлагатай нийцэж байна.
- Оюутнууд багш нарынхаа хандлага дэмжлэгийг сайнаар үнэлсэн.
- Багшийн хөндлөнгийн үнэлгээг сургалтад оролцогчоос асуумжаар жил бүр, сэтгэл ханамжийн судалгааг улирал тутамд авч үр дүнг тооцдог нь хөтөлбөрийн чанар, багшийн албан тушаалын зэрэглэл болон урамшууллын бодит үндэслэгээ болж байна. Жишээ нь: Уг судалгааны дүнгээр эхний 3 байрт орсон багш нарт мөнгөн урамшуулал олгодог бол сүүлийн 5 байрт сануулгын арга хэмжээ авдаг байна. Оноог багш бүрээр гарган байр эзлүүлэн, багш нарын авсан дундаж оноогоор тэнхимийн дундаж оноог гарган жагсаадаг юм байна.

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Урьдчилсан үнэлгээний дагуу бүрдүүлсэн нотломжууд
- Оролцогч талуудтай хийсэн цахим уулзалт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2019-2020 оны хичээлийн жилд ХЧДБ, МИ-лэл хариуцсан төв байгуулсан. Энэхүү төвийн мэргэжилтэн нь ХЕХ-ны нарийн бичгийн ажил хавсран СА-ны бүтцэд багтан ажилладаг. ХДХ-той хамтран ажилладаг нь ажил үүрэг нь нягт оновчтой юм. Тус төв нь хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн үр нөлөө гэсэн 3 чиглэлээр чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журмын дагуу үнэлгээг хийж жилийн эцэст үр дүнг тайлагнаж хэвшжээ. ОУУБИС-ийн сургалтын журмын 4.14.8.5-д “Хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээг ажил олгогчийн сэтгэл



ханамжийн судалгаа, төгсөгчийг мөшгөх судалгаа, хөдөлмөрийн зах зээлийг тандах судалгааны үр дүнд үндэслэн хийнэ ” гэж заасан. Энэ журмын дагуу Англи хэлний тэнхим судалгаа авч 2018-2019 онд 3,52 оноо, 2019-2020 онд 4,56 оноогоор үнэлэгджээ.

- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талууд хөтөлбөр хэрэгжилтийн бүх ажиллагаанд тодорхой үүрэгтэй ажилладаг байна.

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуултын өөрийн үнэлгээний тайланд SWOT TOWS анализ хийсэн байдал
- Өөрийн үнэлгээний тайлан
- Урьдчилсан үнэлгээний дагуу бүрдүүлсэн нотломжууд
- Оролцогч талуудтай хийсэн цахим уулзалт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Ажил олгогчид нь төгсөгчдөд мэргэжил мэдлэгээс гадна хандлага соёлд нь сэтгэл ханамжтай байдгаа илэрхийлсэн нь тус сургуулийн Солонгос соёлтой холбоотой бололтой.
- Төгсөгчид, суралцаж байхад нь төрөл бүрийн тэтгэлэг олгон дэмжин сургаж хөгжүүлсэнд сэтгэл ханамж өндөр байдаг бөгөөд өөрөө хичээвэл хөгжих өргөн боломж байдгыг итгэлтэй илэрхийлсэн.
- Судалгаагаар төгсөгчдийн ажил эрхлэлт 2019 онд 79,1%, 2020 онд-82,4% байгаа нь жил ирэх тусам ажил эрхлэлт өсөх хандлагатай байна. Мөн төгсөгчдийн карьер өсөлт англи хэлний мэдлэг, чадварын давуу талаараа төр, хувийн хэвшлийн байгууллагад хөрвөн ажиллах боломж өндөр байна. Ажил эрхлээгүй төгсөгчдийн 53,6% үргэлжлүүлэн сурч байгаа бөгөөд үлдсэн хувь нь хувийн болон эрүүл мэндийн шалгаантай. Төгсөөд шууд эсвэл 4 сарын дараа ажилд орж байгаа нь ажил хүлээлт бага байна.
- Багш ,оюутанд жил бүр Солонгос эрдэмтэд ирж хувь хүний хөгжлийн сургалт явуулдаг нь нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамж бий болгоход үр нөлөөтэй байна.
- Хийж буй ажил үүрэг ба эзэмшсэн мэргэжлийн нийцлийг 14 үзүүлэлтээр дүгнэхэд 23,75% нь маш сайн, 41,4% сайн, 21% дундаж, 5,5% бага, 16,7% огт нийцээгүй гэсэн судалгаа гарчээ.
- Ажил олгогч болон төгсөгчдийн төлөөлөлтэй онлайн уулзалт хийхэд тэдний сэтгэгдэл эерэг байсан.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ОУУБИС 2 удаа байгуулгын магадлан итгэмжлэл хийлгэсэн.
- ОУ-ын стандартын ISO9001:2008 гэрчилгээтэй.
- АХТ-ийн хамт олон нь Гадаад хэлний орчуулга (Англи хэл), 023101 индекс бүхий бакалаврын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд анх удаа хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэх өөрийн үнэлгээний тайлан бичиж танилцуулсан. Тайлангийн баримт нотолгоог зохих түвшинд бэлтгэсэн байдал
- Цаашид ОУ-ын магадлан итгэмжлэлд орох төлөвлөгөө
- Өөрийн төгсөгчдөд ахисан түвшинд суралцахад тодорхой хөнгөлөлт үзүүлдэг: Одоогоор сургалтын төлбөрийн хөнгөлөлтөөр 5 магистр төгссөн, 6 магистрант сурч байна. Цаашид төгсөгчдийн 62,3% эчнээ, оройн ангиар суралцах хүсэлтэй. Тандалт судалгаагаар төгсөгчдийн 77,5% магистрт, 8,5% докторт суралцах хүсэлтэй байна гэсэн баримтууд

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдөө ахисан түвшинд суралцахад 20 хувийн хөнгөлөлт үзүүлдэг нь суралцагчдад бодит дэмжлэг бөгөөд эерэг үнэлэмж хандлага төрүүлдэг байна.

#### **Зөвлөмж:**

- Ахисан түвшинд суралцагчдад ажлын байрнаасаа холдохгүй зайн, хамтарсан сургалт явуулж болох юм.

#### **7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## ДУГНЭЛТ

Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн “ Гадаад хэлний орчуулга /Англи хэл/ D023101 хөтөлбөрийн шалгуур хангасан үзүүлэлтийн товчоо

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3	0	0	
2	Сургалтын үйл ажиллагаа	3	0	0	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	2	1	0	-Номын фондын баяжуулалтыг тогтмол хийж байгаа ч тус хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудын 50 гаран хувь нь номын фондын хүрэлцээнд сэтгэл ханамж дунд ба түүнээс доош гэсэн үнэлгээ өгсөн. -Номын фондын бүтцэд эрдэм шинжилгээний сэтгүүл, цахим номын эзлэх хувь бага.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1	0	-ОУУБИС-иас гадаад харилцаагаар 90 гаруй их дээд сургуультай гэрээтэй ажиллаж байгаа маш их боломжийг англи хэлний орчуулагч мэргэжлээр багш болон оюутан солилцоонд өргөн ашиглах. - “2+2” хөтөлбөрөөр оюутан сургах цаашдын боломжоо бүрэн ашиглах, ийм хөтөлбөрт хамрагдах оюутан зорилттой бэлтгэхэд анхаарах.
5	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	5	0	0	

6	Багшийн үйл ажиллагаа	4	0	0	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	0	0	
<b>Дүгнэлт</b>		Бүрэн хангасан 24, Хэсэгчлэн хангасан 2, Хангаагүй 0			
		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн “Гадаад хэлний орчуулга /Англи хэл/ D023101 хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... /Т.Төрбат/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Р.Наранцэцэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ч.Шинэбаяр/

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	Олон Улсын Улаанбаатарын их сургууль
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Гадаад хэлний орчуулга /Англи хэл/
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D023101
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Англи хэлний орчуулагч мэргэжлээр төгссөн төгсөгч өөр салбарт хөрвөж ажиллах боломж их байгаа нь тухайн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай болохыг нотолж байгааг харгалзан оюутанд санал болгох төлөвлөгөөнд ажил олгогчдоос санал авч орчуулгын сонгон суралцах хичээлийн нэр төрлийг нэмэгдүүлэхэд анхаарах.</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>➤ Оюутны дүнгийн талаар сургалтын албаны гаргадаг статистик чанарын болон тоон үзүүлэлтэд хийсэн анализыг дараагийн хичээлийн жилийн ажилд тусгаж байх аргачлалд анхаарах.</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>➤ Эрдэм шинжилгээний сэтгүүл, мэргэжлийн сэтгүүл болон цахим номын нэр төрөл, тоог нэмэгдүүлэх.</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>➤ ОУУБИС-иас гадаад харилцаагаар 95 их дээд сургуультай гэрээтэй ажиллаж байгаа өргөн боломжийг багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг олон хэлбэрийн хамтын ажиллагаагаар англи хэлний орчуулагч бэлтгэх сургалтын чиглэлээр идэвхжүүлэх, англи хэлний орчуулгын дадлагаар оюутан солилцоог идэвхтэй ашиглах талаар судлах.</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>➤ Сүүлийн 6 жилийн төгсөгчдийн дөнгөж 2.2% нь дипломын ажил хамгаалсан байна. Оюутнуудыг судалгааны арга барилд сургах, судалгааны ажилд сонирхолтой болгох, улмаар дипломын ажил бичих оюутны тоог нэмэгдүүлэхэд анхаарах.</li> <li>➤ Төгсөлтийн бичиг баримтад зөвхөн дүнгийн хавсралтаар хязгаарлахгүй тухайн төгсөгчийн эзэмшсэн мэдлэгийн агуулга, ур чадварыг багтаасан бүрэн дүүрэн мэдээллийг хавсаргаж өгөх (Diploma supplement).</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>➤ Багшийн сургалтын цагийн ачаалал 13-19 кр байгаа нь бусад их дээд сургуультай харьцуулахад өндөр байна. Цаашид сургалтын цагийг бууруулан эрдэм шинжилгээ судалгааны цагийг өсгөх нь өнөөгийн их сургуулийн шаардлагад илүү нийцэн, багшийн хөгжилд эерэгээр нөлөөлөх боломжийг ашиглах нь зүйтэй байна</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Ахисан түвшинд суралцагчдад ажлын байрнаасаа холдохгүй зайн, хамтарсан сургалт явуулж болох юм.</li> </ul>

**ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/**

	<ul style="list-style-type: none"> <li>➤ Тус хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудын 50 гаран хувь нь номын фондын хүрэлцээнд сэтгэл ханамж дунд ба түүнээс доош гэсэн үнэлгээ өгсөн байгааг харгалзан номын фондын бүтцэд эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл, мэргэжлийн цахим номын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарах.</li> <li>➤ ОУУБИС-иас гадаад харилцаагаар 90 гаруй их дээд сургуультай гэрээтэй ажиллаж байгаа арвин боломжийг англи хэлний орчуулагч мэргэжлээр багш болон оюутан солилцох ажилд өргөн ашиглах.</li> </ul>
--	--

**IV. Ярилцлагад оролцогчдын нэрс**

I. Багш нар

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Ажилласан жил
1	Т. Мягмарсүрэн	Тэнхимийн эрхлэгч	Монгол Англи орчуулга, Найруулга зүй, Үгсийн сан, Хуулийн орчуулга	12
2	Ш. Сэрчмаа	Дэд профессор	Илтэх чадвар, Хэлмэрчлэхүй, Сонсох Ярих, Америк судлал, Британис судлал	17 /7/
3	Б. Жигжидсүрэн	Дэд профессор	Авиа зүй, Орчуулгын онол, Орчуулгын арга зүй, Бизнес эзийн засгийн орчуулга, Англи – Монгол оруулга	12
4	Д. Батсайхан	Ахлах багш	Бичих чадвар, хэлзүй, албан бичгийн орчуулга, Өгүүлбэр зүй	12
5	Л. Алтантуяа	Ахлах багш	Үгзүй, Унших бичиг, анагаах ухааны орчуулга,	13
6	Н. Ууганцэцэг	Багш	Англи Америк уран зохиол, Аялал жуулчлалын. Орчуулга, Хэвлэл мэдээллийн орчуулга, Уран зохиолын орчуулга	12

## II. Оюутны төлөөлөл

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар
1	Б. Сансармаа	АХО-1	УБ хот	88272789
2	Отгон-эрдэнэ	АХО-1	Хөдөө орон нутаг / Оюутны байр / хөгжлийн бэрхшээлтэй оюутан	88433860
3	Галмандах	АХО-1	УБ хот –Суралцангаа ажил эрхэлдэг	89928632
4	Тэмүүжин	АХО-1	Хөдөө орон нутаг	90666414
5	Энхжин	АХО-1	УБ хот	99130412
6	Арайлым	АХО-1	Баруун аймгаас суралцаж байгаа оюутан –Баянөлгий	99722290
7	Б. Анужин	АХО-2	УБ хот 2+2 хөтөлбөр т хамрагдахаар суралцаж байгаа	80252064
8	Билгүүн	АХО-2	УБ хот	96751209
9	Ө.Нямсүрэн	АХО-2	УБ хот	99983981
10	Пүрэвдорж	АХО-2	УБ хот	91167688
11	Яна	АХО-3	ОХУ-гаас суралцаж байгаа оюутан Тува	
12	Анужин	АХО-3	Тэтгэлэгт хамрагдсан	89130519
13	Булганцэцэг	АХО-3	Тэтгэлэг	85889441
14	Ш. Бадамханд	АХО-3	Тэтгэлэг	86232468
15	Б. Сонинцэцэг	АХО-4	Хөдөө орон нутаг Эрдэнэт хотоос сурцалцаж байгаа	94354907
16	Ц. Азжаргал	АХО-4	Хөдөө орон нутаг Дорнод аймаг	99664984
17	Б. Хэрлэн	АХО-4	Суралцангаа ажлын байр хангагдсан	99777066
18	Энхдөлгөөн	АХО-4	Солонгост оюутан солилцоогоор сурч байна	
19	Мөнхтуул	АХО-4	Тэтгэлэг	89170099
20	Мөнхтөгс	АХО-4	Хөдөө орон нутаг- Сэлэнгэ аймаг	85554541
21	Халиунаа	АХО-4	Тэтгэлэг	89897261
22	Сүхбат	АХО-4	Хөдөө орон нутаг-Өмнөговь	98818282
23	Лхагвадулам	АХО-4	УБ	88187469

III. Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэр	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	Yoon Jong Chan	Захирал	Ай Ти Партнерс” ХХК	95549777
2	Буянжаргал	Ахлах менежер	Эталон Комфорд ХХК	90196162
3	Б.Баатарцогт	Гадаад хэлний тэнхимийн эрхлэгч	Мандах ИС	99998733
4	Г.Даваахүү	Гүйцэтгэх захирал	Ди Эм Эл ХХК	99047396
5	П. Туяа	Гүйцэтгэх захирал	Нарны Хүүхдүүд ТББ	99718917
6	Энхчимэг	hi-payment solutions LLC	call center manager	90000090
7	Ц.Алтансүвд	Cabin crew manager	Aeromongolia Airline	99192766
8	Ц. Мөнхсайхан	Гүйцэтгэх захирал	Түмэн занги ХХК	99020637
9	М.Номин-Эрдэнэ	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Ард Кредит ХК	89190852
10	Баяраа	Программ тайлангийн мэргэжилтэн	Golomt bank	88057081

IV. Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэр	Төгссөн он	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	З. Тэлмүүн	2015	Багш	Мандах ИС	80903091
2	Билгүүн	2015	МУБИС	Магистрант	95995553
3	Санчирмаа	2016	Community engagement sponsorship specialist	World Vision Mongolia	95952909
4	Наранцэцэг	2016	Operator		86755050
5	Түмэнжаргал	2017	Хувиараа	Хувиараа Англи хэлний багш хийж байна	99604929
6	Сударчулаан	2017	Захиалгын менежер	Ди Эм Эл ХХК	89980247
7	Жамъянням	2017	Агаарын хөлгийн үйлчлэгч	Hunnu air	96969026
8	Э. Хулан	2018	Чанарын мэргэжилтэн	Ард санхүүгийн нэгдэл	99770202
9	Бүрэнхаан	2018	Англи хэлний багш	Роял Академи	80882832
10	Анударь	2019	Бичиг хэргийн ажилтан	Эмэгтэйчүүдийн эрх хамгаалах	95329832



				хөгжлийн хүрээлэн төрийн бус байгууллага	
11	Нурдаулет	2019	Борлуулалтын менежер	Эталон Комфорд ХХК	99294786
12	Минсэл	2019	Борлуулалтын менежер	IT Partners LLC	88115749
	Одончимэг	2019			88128510
13	Бат-оюун	2020	Багш	The Academy of English	80055578
14	Золжаргал	2020	Борлуулалтын менежер	Эталон Комфорд ХХК	99938344
15	Х.Бат- Амгалан	2019	Flight attendant, Marketing manager	Aeromongolia Airline	88090833
16	Х. Саруул	2015	Ээлжийн менежер	Түмэн занги ХХК	89808887

Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн “Гадаад хэлний орчуулга  
/англи хэл/” D023101 хөтөлбөрийн оролцогч талуудтай хийсэн  
уулзалтуудын товч тэмдэглэл

2021-03-03, 04

Шинжээчийн багийн ахлагч: Т.Төрбат  
Шинжээчийн багийн гишүүн : Р.Наранцэцэг  
Шинжээчийн багийн гишүүн: Ч.Шинэбаяр

#### Оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл

Т.Төрбат: Та бүхэнд тодорхой санал байгаа эсэх

Р.Наранцэцэг: Энэ сургууль, мэргэжлийг яагаад сонгосон бэ? Сайжруулах зүйл, санал байна уу?

- 1р курс. Би 33 настай. Энэ мэргэжлийг нэлээн хожуу сонгосон. Анх бүртгүүлэх гээд ирэхдээ л ЭЕШ-ын хөнгөлөлт эдэлсэн. Ингэж хөнгөлөлт эдэлнэ гэж төсөөлөөгүй байсан болохоор сайхан байсан. Орчин нөхцөл зүгээр. Гэхдээ номын сангийн зай талбайг сайжруулмаар санагдсан. Хүүхдүүд кофе шоп, цайны газарт хичээлээ хийж байгаа харагддаг.
- 1р курс. Би бусдаас арай ялгаатай, тэргэнцэртэй оюутан. Лифттэй болохоор нь энэ сургуулийг сонгосон. Сургуулийн орчинд налуу зам хийж тусалсан. Харин А байранд лифт байдаггүй. Англи хэл ихэвчлэн А байранд ордог. Энэ байрандаа лифттэй болох саналыг өгсөн. Халамжийн тэтгэлэг сургуулиас өгсөнд талархаж байна.
- 2р курс. Энэ мэргэжил зайлшгүй шаардлагатай хэрэгтэй гэж бодоод сурч байна. Академик мэдлэг сайн авч байна. Тухайн орны түүх, соёл үздэг нь таалагддаг. Багш нарын ёс зүй, харилцаа сайн. Цахимаар хичээлээ үзэхэд датанаас болоод хүндрэлтэй байхад сургуулиас шийдэж өгсөнд нь талархаж байна. Цаашид технологийн дэвшлийг илүү ашиглавал зүгээр санагдаж байна.

- Анх 12 дугаар ангидаа сургуулийн танилцуулгыг авч байсан. Анхнаасаа л энэ мэргэжил нүдэнд туссан. Гадаад хэлний мэдлэг хүний амьдралд их чухал гэдгийг танилцуулгаас мэдсэн. Тэнхим, багш нартай уулзсан анхны сэтгэгдэл сайхан байсан. Багш нар харилцаа сайтай. Миний хувьд англи хэлний хоцрогдолтой байсан болохоор чирэгдэх болов уу гэж айж байсан. Багш бүр тулж ажиллаад, хичээл хийх орчин сайн бүрдсэн. Интернет, компьютер чөлөөтэй. Upstream elementary номноос эхэлж үзсэн нь надад таарсан.
- 3р курс. Англи хэлний хичээлүүд бүгд түвшин түвшингээрээ явагддаг. Хоцрогдол гардаггүй. Хичээл бүр семинарын цагтай. Энэ нь их таалагддаг. Багш нар харилцаа сайтай, бидэнтэй тулж ажилладаг, бидний санал хүсэлтийг сонсдог. Орчин цэвэр. Сургалтын чанар сайн.

Дадлага хийсэн үү?

- Дадлага хийх үед хөл хорио гараад хойшлогдсон байна.

Т.Төрбат: Сонгох хичээлээс ямар хичээл сонгосон бэ? Хэдэн кр цуглуулсан бэ?

- Байхгүй. Сургалтын албанаас санал болгосныг удирдлага болгож байна.

Нэмүү кредит судалсан суралцагч байна уу?

- Байхгүй. Бусад хичээлийн дүнгээ ахиулах зорилгоор нэмж судалдаг.
- 4р курс. Би 5 жил оюутны байранд амьдарч байна. Манай сургуулийн оюутны байр бусад сургуулийхаас илүү тохитой сайхан. Би тэнхимийн үйл ажиллагаанд туслаад 2 удаа тэтгэлэг авсан. Багш нар маань сайхан. Аман орчуулгын дадлагаа АНУ-д working travel хийсэн. Багш нарын заасан зүйл их хэрэг болсон. Тухайн орны соёлтой танилцсан.

Т.Төрбат: Хэн зуучилж, зохицуулсан бэ?

- Тэнхимийн зарын самбараас харсан. Гадны байгууллагаар явсан. Нэвтрүүлэгч болох сонирхолтой хүнд аман орчуулга илүү орох гэх мэт сонирхсон чиглэл рүү нь түлхэц болвол зүгээр байх.

Оюутан өөрөө бие дааж нэмж кр цуглуулах чөлөөт боломж хэр байна?

- Би өөрөө тийм зорилт тавиагүй болохоор судлаагүй. Гэхдээ тийм боломж бол байдаг.

Ч.Шинэбаяр: Хувь хүний хөгжилд чиглэсэн арга хэмжээ зохиодог гэсэн. Хамрагдсан хүн байна уу? Дугуйлан секц хичээллэдэг үү?

- Бүжгийн дугуйланд 2 жил явсан.
- Ногоон Ази хөтөлбөрт хамрагдсан. Батламж олгодог нь ажил дээр гарахад нөлөө болсон.
- Жил бүр 1р курсийн оюутнууд хувь хүний хөгжлийн сургалтад хамрагддаг. Би 1р курсдээ Ногоон Ази сайн дурын клубт явж байсан. Улирал бүр тэмцээн уралдаан болдог. Би 2 байгууллагад цахимаар дадлага хийх хүсэлт гаргаснаас 1 байгууллага нь зөвшөөрсөн хариу ирүүлсэн. Орчуулгын газар бас дадлага хийж үзсэн. Өөрөө эрэлхийлбэл боломж их байдаг юм байна гэж харсан.

Багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл

- Манай сургуулийн соёлын онцлог бол хандлага, харилцаа. Дийлэнх багш нар маань арваас дээш жил ажилласан. Харьцангуй тогтвортой, олон жил ажилладаг. Бие

биедээ тусалж, дэмждэг нь оюутнуудад ч нөлөөлдөг. Оюутнуудтайгаа уулзахад ажил дээр гараад бусдаас хандлагаараа ялгарч байна гэдэг.

- Жил бүр Солонгосоос багш нар ирж хувь хүний хөгжлийн сургалт явуулдаг. ЕБС-ийн сурагчдад бас энэ талын сургалт явуулдаг. Хөтөлбөр нь тодорхой, тогтсон байдаг. Анх элсэж ороход нь 1р курсийн оюутнуудад 3-4 өдрийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Сургуулиа танилцуулдаг. Мөн тэнхимүүд оюутнуудаа хүлээн авч, тэнхимээ танилцуулаад зөвлөх багш томилдог. Тэр багш 4 жил тэр сурадцагчаа хариуцдаг. Хичээлдээ ирэхгүй нэг л тохиолдол гарахад ярьж, шалтгааныг нь тодруулдаг. Сүүлийн жилүүдэд сургалтын төлбөрөө нэмээгүй. Хичээлийн жилдээ хэд хэд хувааж төлж болдог.
- Оюутны үйлчилгээний цаг гэж авдаг. Хүүхдүүд сургуульдаа ажиллаад төлбөрөөсөө хөнгөлүүлдэг. Оюутны үйлчилгээний цэнхэр дэвтэр байдаг. Оюутны албанаас квот тогтоож өгдөг.
- Танилцах, аман орчуулгын, үйлдвэрлэлийн гэсэн дадлага хийдэг. Байгууллагаас санал асуулга авч дүгнээд, сургалт дадлагатаа сайжруулалт хийдэг. Дадлагын оноо битүүмжлэлтэй ирдэг. Ажил олгогчийн саналыг нэлээн тусгаж байна. Магистрт суралцах төгсөгчдийн тоо нэмэгдэж байна.

Т.Төрбат: 2 2, 1 1 дээр хоёр сургуулийн кр харилцан хүлээн зөвшөөрөх явдал байдаг. Танай тэнхимийн хувьд кр харилцан хүлээн зөвшөөрөх хэлцэлд хүрсэн зүйл байхгүй гэж харлаа. Суралцагчдын тодорхой хувийг С1 түвшинд хүргэнэ гэсэн зорилт тавьсан байсан. Үүнийг хэрхэн баталгаажуулж байна вэ?

- Манайхаас одоогийн байдлаар явсан хүүхэд байхгүй байна. С1 хүрэх бүх түвшингүүдээ зоогоод өгсөн байгаа. Нийцэх боломжтой гэж үзэж байна. Дүйцүүлэх зохицуулалтыг журамдаа оруулж өгсөн.
- Багш нарт зориулсан дагнасан гарын авлага гарсан уу? Цаашдаа залуу багш нарыг ажилд авахад үйл ажиллагааны соёл уламжлагдаж үлдэхэд багшийн ном их хэрэгтэй байдаг.

Онлайн сургалтаар ирцийг хянаж болно. Оролцоонд дүгнэлт өгөх боломж сургуульд хэрхэн баримтжиж байна вэ?

- Долоо хоногт 2 семистрийн 2 даалгавар, орсон тоолонд даалгавар өгдөг. Үүнийг сургалтын албанд өгдөг, оролцоог нь даалгавраар нь хянадаг. Цагийн хуваариараа ороод явдаг. Хичээлдээ ороогүй хүүхдэд зориулаад линкийг нь тавьдаг. Бүх суралцагч цаг тухайдаа ордоггүй.
- А үнэлгээ 40% 5 жилд, хангалтгүй гэж дүгнэснээ тайлбарлаач.
- Мэргэжлийн хичээлд А 20-30% . Манайд 40% байгаа нь ихэчлээ гэж дүгнэсэн.
- Хичээл нь хөнгөдөөд байна уу, багш хөнгөн үнэлээд байна уу, эсвэл өөр шалтгаан байна уу?
- Сүүлийн үед манай сургуульд элсэж байгаа суралцагчдын англи хэлний түвшин сайн байна. Хүүхдүүд идэвх, санаачлагатай болсон. Кр тооцох шалгалт өгөөд тооцуулаад явдаг. Хэдэн ч кредиттэй хичээл байсан нэг крийн төлбөр авдаг.
- ЕБС-д сурсан англи хэлний түвшинг нь тогтоогоод, түвшингээр нь хөнгөлөөд сургалтын төлбөрөөс хасаад шууд тооцох боломж бий. IELTS, TOEFL оноогоор нь тооцох дүрэм, журамтай.
- Зөвхөн хэл биш ерөнхий суурийн хичээлүүдэд кр тооцох боломжтой. Сүүлийн үед Тува, Буриад, Халимагаас оюутнууд суралцаж байна. Монгол хүүхдүүдтэй ижилхэн төлбөрөөр сурдаг.

- Гаднаас шилжиж ирэхэд таарах хичээлийг нь дүйцүүлдэг. Цаг хугацаа, мөнгийг нь үнэгүйдүүлэхийг хүсдэггүй.

Багш өөрөө судалгааны аргазүйн ном гаргажээ. Сургуулиас дэмжлэг үзүүлдэг эсэх?

- Номын санд 10 ном авдаг. Хүсвэл хэвлэлийн тусламж үзүүлнэ. Б цагт тооцдог. Нэг хэвлэлийн хуудсыг 0.5-аар тооцдог.

Гадаадад хэвлүүлсэн бүтээлийг илүү тооцдог уу?

- Хэрхэн тооцох тухай нарийн журамтай. Бидний бүтээлээс ишлэл авсан бол яах талаар ярилцаж байна. Одоогоор нарийн тооцох журамгүй байна. Зэрэг цол, шагнал урамшуулалд нөлөөтэй. IF өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлбэл өгүүллийн тоогоор 10 сая төгрөг өгнө гэсэн.

Ч.Шинэбаяр: Тэтгэлэг 13 төрөл байна. Голч дүнгийн тэтгэлэг аваагүй байна. Ямар зарчмаар олгодог вэ? Голч дүн 3 байвал диплом бичнэ. Сүүлийн 5 жилд 2 хүхэд диплом бичсэн байна.

- Өмнө нь 3.2 байсныг 3 болгосон. Суралцагчаас саналыг нь асуудаг. Голч дүн 3-аас өндөр боловч шалгалт өгөх хүсэлтэй байсан. Энэ жил 3 хүүхэд диплом бичиж байна.

Мультимедиа студи та нарт ямар өгөөжтэй байна вэ? Та бүхэн бичүүлэхэд өөрсдийгөө бэлэн болсон гэж дүгнэж байна уу?

- Цахим сургалт эхлээд screenrecorder –аар хичээлээ бичиж байсан, бэрхшээлтэй байсан. Тэгээд 4 сараас студи байгуулж эхэлсэн. Бид ямар хичээлээр хэзээ бичүүлэхээ захиалдаг. Хуваарь гаргаад, сургалтын алба зохицуулдаг.
- Овоо туршлага хуримтлуулсан. Энэ намар вэбинар хичээл явсан.

Лайв сургалтын бичлэгийг хадгалдаг уу?

- Бүгдийг хадгалдаг. Гүүгл эрх авахын давуу тал нь хязгааргүй хугацаагаар хадгална.

Р.Наранцэцэг: Онлайн хичээлээ яаж үнэлж байна?

- Хэвийн үнэлж байна. Орсон хичээл болгоны тоогоор даалгавар өгдөг. Чанартай даалгавар өгөхийг зорьж байна. 2016 онд А/174-ын дагуу боловсруулсан. 2018 онд шинэчилсэн. Хичээлийн кодуудаа сольсон.

Т.Төрбат: Улиралд 18 кр судлаад түрүүлж төгсөх хүсэлтэй хүүхэд хэр их байна?

- Байдаг. Хүсвэл 3.5 жилээр төгсдөг.

Сонгох хичээлийн хувьд групп бүрдэлт дээр бэрхшээл гарч банья уу?

- Бэрхшээл гардаггүй. Зохицуулалтыг хийгээд явдаг.

Хэлмэрч гэдэг дээр нэмэлт юм бодохгүй бол дангаараа чадахгүй болов уу. Нэмж кр үзээд 120-оос давуулж судлах боломжийг сургууль судлах, танайд тийм боломж байх боломжтой.

- Хавсарга хөтөлбөр гэж сургуульд байдаг.

Бэлтгэл курс гэж байна уу? Оноо хүрэхгүй ч танайд элсэх хүсэлтэй хүүхдүүдэд зориулсан.

- Байхгүй. Гадаад оюутанд зориулан хэлний бэлтгэл явуулдаг.

Ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын тэмдэглэл

Р.Наранцэцэг: Танайд ажиллаж буй ажилчдаа хэрхэн үнэлж байна? Шаардлагад нэмэх санал байна уу?

- Манайд багшилж буй төгсөгч маань биеэ сайхан авч явдаг, ажилдаа хариуцлагатай сайн ажилладаг.

Ч.Шинэбаяр: Өмнө нь танай байгууллагад дадлага хийж байсан уу, эсвэл шууд ажилд орсон уу? Дадлагын оюутан авдаг уу?

- Шууд манайд ажилд орсон. IELTS-ийн өндөр оноотой төгсөгч манайд ажиллаж байгаад баяртай байдаг. Мэргэжлийн англи хэл заадаг.
- Шууд орсон.
- Манай гадаад харилцаанд ажилладаг, шууд ажилд орсон. Англи хэлний бичиг, ярианы орчуулга хийдэг. Солонгосоор бас ойлголцдог.
- Дадлага хийгээгүй ажилд орсон. Төсөл дээр ажилладаг. Харилцааны чадвар сайтай.
- 2019 онд шууд ажилд орсон. Менежерээр ажилладаг. Хамтран ажиллах чадвар сайтай. Суурь хүмүүжил сайтай. Цаашид өсөн дэвших боломжтой.
- Дадлага хийгээгүй, шалгаруулалтаар тэнцээд орсон. Англи хэлний чадвар сайтай. Зохион байгуулалт сайтай. Агаарын хөлгийн үйлчлэгчээр ороод 2 жил болсон, удахгүй ахлах үйлчлэгч болох гэж байна. Маркетингийн хэлтэст давхар ажилладаг.
- Нэг төгсөгч 5 жил ажиллаж байна. Маркетинг хариуцдаг. Англи, солонгос хэлтэй. Хариуцлагатай ажилладаг. Техникийн салбар тул тэр талын мэдлэг дутмаг. Энэ сургуулиас манай байгууллагад дадлага хийгээгүй, өөр сургуулиас бол дадлага хийж байсан. Сэтгэл ханамжийн судалгааг дадлага хийлгэсэн сургуулиас авч байсан. Тус сургууль асуулга авч байгаагүй. Дадлагын оюутан авахад бэлэн байна.

Т.Төрбат: Сургуулиас та бүхэнтэй хандаж байсан уу?

- Ур чадвар нь ямар байна гэж 2-3 удаа холбогдож байсан. Улсын сургуулиас илүү хувийн сургуулиуд ханддаг. Ямар албан тушаалд ажиллаж байна, цаашид ямар албан тушаалд ажиллах боломжтой вэ гэх зэргээр асуудаг. Цөөнгүй төгсөгчид нь ажилладаг. Хүний нөөцтэй холбогдож байсан байх.

Төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн цахим үүлзалтын товч тэмдэглэл

Ч.Шинэбаяр: Мэргэжлээрээ, бас өөр мэргэжлээр ажиллахад ямар хүндрэл гарч байна? Олсон мэдлэг, чадвар хангалттай байна уу?

- 2017. Аялал жуулчлалын компанид мэргэжлээрээ ажилласан. Одоо өөр ажил хийж байна. Онгоцны үйлчлэгч хийдэг.

Мандах их сургуульд багшлахад сургуульд сурсан бизнесийн англи хэлний хичээл ямар байв?

- Сургуульд сурсан бизнесийн англи хэлний мэдлэг Мандах их сургуульд ажиллахад хаана ч хүрэхгүй нь мэдээж. Гэхдээ богино хугацаанд мэргэшсэн.

Т.Төрбат: Сургуулийн давуу тал юу вэ?

- 2019. Олон төрлийн тэтгэлэг, боломж олгодог. Солонгост нэг сарын тэтгэлэгт яваад ирсэн. Тэнхимээсээ тодорхойлогдоод явсан. Тайландад бас яваад ирсэн. Оюутны зөвлөлд ажиллаж байсан. Овутан өөрөө хичээвэл олон төрлийн тэтгэлэгт хамрагдах боломжтой.
- Хүн өөрөө л хичээвэл тэтгэлэг авах боломжтой. Багш, суралцагчийн хоорондох харилцаа сайн. Оюутнуудаа сайн анхаардаг.

Р.Наранцэцэг: Сурч байхдаа сургуульдаа ажилласан уу?

- Нийгмийн ажил хийж тэтгэлэг авдаг байсан.
- 2017. Долоо хоногт нэг удаа тэнхимийн цэвэрлэгээ хийгээд тэтгэлэг авч байсан.

Т.Төрбат: Суралцах хугацаанд тэтгэлэг авах боломжийг ярьлаа. Гадны байгууллагуудаас санал болгосон, эсвэл оролцож байсан ямар ажил байна?

- 2018. Оюутны байр сургуулийн хажууд байдаг. Автомат угаалгын машинтай, их тохилог. Сурч байхдаа World vision байгууллагад орчуулагч хийж байсан.

Ч.Шинэбаяр: Дадлага хэр үр дүнтэй байсан бэ?

- 3 удаа хийдэг. Үйлдвэрлэлийн дадлагаа аялал жуулчлалын байгууллагад хийгээд, ажлын урилга ирээд 2 жил ажилласан.
- Дадлага хийсэн газраа ажилд орсон хүүхдүүд байдаг.

Т.Төрбат: Төгсөгчдийн холбооноос та нартай холбогдсон уу?

- Ямар ажил эрхэлж байгаа талаар судалгаа авдаг. Ажилд зуучилдаг.

Р.Наранцэцэг: Оюутан байхдаа эрдэм шинжилгээний хуралд оролцож байсан уу?

- Их, бага хэмжээний эрдэм шинжилгээний хуралд оролцож байсан. Англи хэлний олимпиадад оролцож байсан.
- Жил бүр болдог байсан. Бас best presenter болдог байсан.

Т.Төрбат: Клуб дугуйланд хамрагдаж байсан уу?

- Бүх тэнхимд клуб байдаг. Манайд англи хэлний илтгэлийн дугуйлан явдаг байсан. Чих нээгдэх, нүүр хагарах давуу талтай.

Р.Наранцэцэг: Төгссөний дараа дүгнэхэд ямар ур чадвар, хичээл нэмэх санал байна уу?

- Англи хэлний орчуулагч хөтөлбөрөөр бүх түвшинд сайн судалдаг. Суурь сайн тавигдаагүй хүүхдэд гүнзгий судлагдахууныг заах нь сөрөг нөлөө үзүүлсэн байж магадгүй. Ач холбогдлыг нь таниулах нь чухал гэж бодож байна.

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН  
ИХ СУРГУУЛЬ**

210644 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг  
Намянжүгийн гудамж, Утас: 462046 Факс: 976-11-462040  
E-mail: info@iuu.edu.mn, iuu.edu.mn

2021.03.17 № 1/82

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Шинжээчийн тайлантай танилцсан тухай

Тус сургуулийн Англи хэлний тэнхим нь “Гадаад хэлний орчуулга /Англи хэл” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд өгсөн шинжээчийн багийн тайлантай танилцлаа. Ямар нэг санал, хүсэлт, гомдол байхгүй болно.

Бидний зүгээс шинжээчийн багийн өгсөн дүгнэлт, санал, зөвлөмжийн дагуу өөрийн үнэлгээний тайлан, мэргэжлийн хөтөлбөрөө цаашид сайжруулж ажиллах болно.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ~~ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ~~ ЧОЙ ГИ ХО



## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2021-03-22  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**